



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/312

Номгон

「Баянхонгор аймгийн Бахархалт 80 иргэний
түүхэн материал, ярилцлага, нэвтрүүлгээр
Төрийн архивын санг баяжуулах тухай


Аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 м, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол улсын түүхэнд үнэтэй хувь нэмэр оруулсан Баянхонгор аймгийн бахархалт 80 иргэний түүхэн материалыг ярилцлага, нэвтрүүлэг хэлбэрээр Төрийн архивын үндсэн санг баяжуулах ажлыг зохион байгуулсугай.

2.Сан бүрдүүлэх үйл ажиллагаанд зарцуулах 1.500.000 (Нэг сая таван зуун мянган) төгрөгийг Ойн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Төрийн архивын сан хөмрөгийг баяжуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төрийн архив (В.Эрдэнэчимэг), Хэвлэл мэдээллийн алба (Б.Батгэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, баяр наадам зохион байгуулах комисс /Б.Батсуурь/-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

521010797